

СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ УЛИРЛЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг жигд, тогтвортойгоор хангах, үнийн зохиомол хөөрөгдлөөс сэргийлэх зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөц (цаашид “нөөц” гэх)-ийг бүрдүүлэх, хадгалах, зарцуулах харилцааг зохицуулна.

1.2. Хүнсний тухай хуулийн 6.3, 6.5-д заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хоёр. Нөөцийн нэр төрөл, бүрдүүлэх үйл ажиллагаа

2.1. Нөөцөд малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, цэвэр ус хамаарна.

2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар нутаг дэвсгэрийнхээ хүн амын тоо, өсөлттэй уялдуулан өөрийн орон нутгийн стратегийн хүнсний хэрэгцээ, эрэлт, нийлүүлэлтийг судлан, тухайн жилийн улирлын нөөц бүрдүүлэх стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож, саналыг хүнсний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 1-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.3. Хүнсний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага журмын 2.2-т заасан саналыг нэгтгэн дүгнэж, Монгол Улсын стратегийн хүнсний улирлын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээний саналыг, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.

2.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засгийн газраас тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан орон нутгийн стратегийн хүнсний улирлын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, чанарын шаардлага болон бүрдүүлэх, хадгалах, зарцуулах, хугацаа, хуваарийг өөрийн орон нутгийн онцлогт тохируулан захирамжаар баталж, мөрдөж ажиллана.

Гурав. Нөөцийн түүхий эд, бүтээгдэхүүн болон үйлдвэрлэгч бэлтгэн нийлүүлэгчидэд тавигдах ерөнхий шаардлага

3.1. Нөөц бүтээгдэхүүн нь нэр төрлөөс хамааран холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.

3.2. Нөөц бүтээгдэхүүн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.-т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа

боодолд савласан байх, 12.4.- т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгоны мэдээллийг бүрэн агуулсан байна.

3.3. Нөөц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгч нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

Дөрөв. Нөөцийг бүрдүүлэх эх үүсвэр, арга зам

4.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн болон нийслэлийн төсвийн хөрөнгөнөөс улирлын нөөцийг бэлтгэхэд шаардагдах эх үүсвэрийн 100 хүртэл хувийг бүрдүүлж болно.

4.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан нөөц бүрдүүлэх, хадгалах, борлуулах хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч (цаашид хуулийн этгээд гэх)-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.

4.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь нөөцийг өөрийн орон нутгийн онцлогтой уялдуулан эх үүсвэрийн 100 хүртэл хувийг хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрээр бүрдүүлж болно.

4.4. Гэрээнд нөөцийн нэр төрөл, хэмжээ, чанар, аюулгүйн үзүүлэлт, нийлүүлэх, борлуулах үнэ болон бүрдүүлэх, хадгалах, борлуулах, хугацаа, хуваарь, эрсдлээс шалтгаалан гэрээний заалт үл биелэгдэх нөхцөл үүсэх, түүнээс гарах үр дагавар, хариуцлагын талаар тусгасан байна.

4.5. Хуулийн этгээд нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагыг хангасан, гэрээний хугацаанд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг биелүүлнэ.

4.6. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын 329 дүгээр тогтоолоор батлагдсан Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын дагуу нөөцийг нэмэгдүүлж болно.

Тав. Нөөцийг бүрдүүлэх, зарцуулах нэгдсэн удирдлага, хяналт

5.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нөөц бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах үүрэг гүйцэтгэнэ.

5.2. Аймаг нийслэлийн Засаг дарга Хүнсний тухай 6 хуулийн 6.3, 6.5-д хүлээсэн үүргийн дагуу нөөц бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг баримтлан, өөрийн орон нутгийн онцлогтой уялдуулан зохион байгуулна.

5.4. Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хуулийн дагуу сонгогдсон хуулийн этгээдүүд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр нөөц бүрдүүлэх, борлуулах үйл ажиллагааг зах зээлийн харилцааны дагуу гүйцэтгэнэ.

5.5. Аймаг, нийслэлийн хяналтын байгуулага нь нөөцөд хадгалагдаж буй стратегийн хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, баталгаажилт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.

5.6. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтын тоо хэмжээнд хөндлөнгийн хяналт тавина.

5.7. Сум, дүүргийн Засаг дарга, төрийн бус байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрийнхээ нөөцийн тоо хэмжээ, үнэ, хуваарийн дагуу зарцуулалтын байдалд хяналт тавина. Энэхүү хяналтыг хэрэгжүүлсэн тухай тайлан болон авах арга хэмжээний талаарх саналыг тухай бүр аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ.

5.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулахаар шалгарсан хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд бүхэлд нь хяналт тавьж ажиллана.

Зургаа. Хариуцлага

6.1. Нөөцөд бүтээгдэхүүн нийлүүлэхээр олгох хуулийн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль болон тухайн гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.